

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТАЙЛАН

2021.01.04

Улаанбаатар хот

Авлигатай тэмцэх газар Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, 2020 онд дэвшүүлсэн зорилтыг ханган биелүүлэх чиглэлээр дараах ажил, арга хэмжээг хэрэгжүүлж ажиллалаа. Үүнд:

Нэг. Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын талаар:

1.1 Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх хэсэгт заасан “улсын хэмжээнд авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах, нэгдсэн хөтөлбөр боловсруулах, арга зүйн удирдлагаар хангах, хэрэгжилтэд нь хяналт тавих” чиг үүргийн хүрээнд тайлант хугацаанд Зам, тээврийн хөгжлийн яам, Авто тээврийн үндэсний төв, Цагдаагийн ерөнхий газрын харьяа Бүртгэл хяналтын төв, Сонгинохайрхан дүүрэг дэх Газрын алба, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Налайх, Багануур дүүрэг, Төв аймгийн Заамар суманд тус тус ажиллав. Ийнхүү ажиллахдаа авлига, ашиг сонирхлын эрсдэлийг тогтоох, түүнээс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомж зөрчсөн, төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй байдлыг хангаагүй, хүнд суртал бий болгосон, албан тушаалтан болон бусад этгээдэд давуу, ашигтай байдал бий болгож байгаа нөхцөл байдлуудыг тогтоон, зөрчлийг газар дээр нь арилгуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө болон мэдээ, мэдээлэл өгөх зэрэг цогц арга хэмжээг хэрэгжүүлэв. Үүнд:

Зам, тээврийн хөгжлийн яам, Авто тээврийн үндэсний төвийн автомашины улсын дугаар олголт, бүртгэлийн үйл ажиллагаа, авлигын гэмт хэрэг гарах шалтгаан нөхцөл, хяналт шалгалтын мөрөөр гарсан зөрчил, дутагдлыг арилгах чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээтэй танилцаж, зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, зарим зөрчил нэмж тогтоогдсон тул “Авто тээврийн улсын дугаар олголт, бүртгэлийн үйл ажиллагаанд гарч буй авлигын эрсдэл” сэдэвт уулзалтыг Зам, тээврийн хөгжлийн яам, Автотээврийн үндэсний төвийн удирдлага, мэргэжилтнүүдийг оролцуулан зохион байгуулж, зөвлөмж гардуулав. Зөвлөмжийн хүрээнд импортоор орж ирж буй авто тээврийн хэрэгслийн техник хяналтын үзлэгийн төлбөрийг давхардуулан тогтоосноор жилд дунджаар 30 орчим тэрбум төгрөг иргэд, аж ахуйн нэгж төлөх байсныг таслан зогсоолоо.

Сонгинохайрхан дүүрэг дэх Газрын албаны үйл ажиллагаан дахь авлига, ашиг сонирхлын зөрчил гарах шалтгаан, нөхцөл, үйлчилгээний хүнд суртлыг тогтоох чиглэлээр дүүргийн Засаг даргын Тамгын газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба болон Газрын алба, дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэс, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Мэдээллийн технологийн газарт тус тус ажиллан, Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн хүрээнд төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, үйл ажиллагааны хоорондын уялдаа холбоонд дүн шинжилгээ хийж, зөвлөмж хүргүүлэв.

Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд ажиллаж, Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмж, Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөр, авлигын эсрэг хууль тогтоомжоор төрийн байгууллага, албан тушаалтанд хүлээсэн нийтлэг үүргийн биелэлттэй танилцаж, тус яамнаас олгодог зарим төрлийн тусгай зөвшөөрөл, мэргэжлийн байгууллагын 19 төрлийн эрхийн гэрчилгээ олгоход баримталдаг хууль тогтоомж, Засгийн газрын тусгай сан болох Байгаль орчин, уур амьсгалын сангийн үйл ажиллагаа, санхүүжилт, хөрөнгийн захиран зарцуулалтын байдал, тус яамны харьяа “Ойн судалгаа, хөгжлийн төв” УТҮГ, “Монгол Ус” ТӨҮГ, “Монгол Кувейтын байгаль хамгаалах төв” ТӨҮГ, “Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв” УТҮГ, “Аялал жуулчлалын хөгжлийн төв” ТӨААТУҮГ-ын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, түүний биелэлтийн талаарх мэдээлэлд дүн шинжилгээ хийв.

Эрүүл мэндийн салбарын авлигын эрсдэлийг тогтоож, шийдвэрлэх арга замыг тодорхойлох, дүн шинжилгээ хийх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулж, 2018-2020 оны хооронд гадаадын зээл тусламжаар хэрэгжсэн, хэрэгжиж буй төсөл,

хөтөлбөрийн үр дүн, тус салбарт хийгдсэн аудитын байгууллагын дүгнэлт, эмч, эмнэлгийн мэргэжилтний давхар ажил эрхлэлтийн байдалд дүн шинжилгээ хийлээ. Нийслэлийн Налайх, Багануур дүүргийн Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах орон нутгийн комиссоос гаргасан хөдөлмөрийн чадвар алдсан хувь хэмжээ, хугацааг тогтоох, сунгах, цуцлах асуудлыг магадлан шийдвэрлэх үйлчилгээ, тухайн үйлчилгээний авлигын эрсдэл, шийдвэрлэх арга замыг тодорхойлон урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгууллаа.

Төв аймгийн Заамар суманд биологийн болон техникийн нөхөн сэргээлт хийх нэрийдлээр иргэн, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, ашигт малтмалын олборлолт явуулж байгааг таслан зогсоох, авлигын эрсдэл, нөхцөл байдлыг тодорхойлох өмнө хүргүүлсэн зөвлөмжийн мөрөөр хийсэн ажлын гүйцэтгэлтэй танилцав.

Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар, Газрын алба, Ашигт малтмал, газрын тосны газраас үзүүлж буй төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан хүсэлт, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, үйл ажиллагааны зохион байгуулалтад тандалт, ажиглалт хийж, иргэн, аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй фокус ярилцлага хийж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, авлига, ашиг сонирхлын зөрчил, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зорилтот арга хэмжээг хэрэгжүүлээ.

Авлигын гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар хүргүүлсэн мэдэгдлийн мөрөөр хийсэн ажлын гүйцэтгэлтэй Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Гадаад харилцааны яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Харилцаа холбооны зохицуулах хороо, Цагдаагийн ерөнхий газар, түүний харьяа нэгж, Төв аймгийн Сэргэлэн, Эрдэнэ сумдын Засаг даргын Тамгын газарт ажиллаж, илэрсэн зарим зөрчил, дутагдлыг газар дээр нь арилгуулан, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөмж хүргүүлэн, биелэлтэд хяналт тавин ажиллав.

1.2 Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь хэсэгт заасан “авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах талаар аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх орон тооны бус зөвлөлд үүрэг, чиглэл өгөх;” чиг үүргийн хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих зорилт, чиглэлийг хэрэгжүүлэхээр 21 аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны тайланг судлан, тус салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нартай цахим уулзалт зохион байгуулж, орон нутаг дахь авлигын нөхцөл байдал, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилт, анхаарах асуудлуудыг танилцуулж, 2020 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар үүрэг, чиглэл өгсөн байна.

21 аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүнг нэгтгээд байна.

1.3 Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.4 дэх хэсэгт заасан “төрийн бус байгууллага, иргэдээс авлигатай тэмцэх талаар явуулж байгаа үйл ажиллагаа, гаргасан санал, санаачилгыг дэмжин туслах, тэдний оролцоог нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах;” чиг үүргийн хүрээнд авлигын эсрэг хууль тогтоомж болон Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр иргэн, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтарч ажиллах чиглэлээр 47 удаагийн уулзалт, ярилцлагыг зохион байгуулав.

Нийслэлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн хурлаар Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны тайлан, 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажиллах журмыг хэлэлцэх хуралдаанд оролцож, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Авлигын эсрэг хуулийн холбогдох заалтуудыг хангах, авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр хэлэлцүүлэг, сургалт зохион байгуулах, сурталчилгаа хийх ажлын хүрээнд нийслэлийн төсвөөс санхүүжилт гарган, хамтран ажиллахаар тогтлоо.

“Залуус өөрчлөлтийн төлөө үндэсний хөдөлгөөн”, “Хуулийн хөтөч” клубтэй хамтран ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд "New generation-No corruption" илтгэх ур чадварын нээлттэй тэмцээнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, уралдаанд түрүүлсэн зохиолуудаас шилдгийн шилдэг нэг зохиолыг сонгож “Brosis Pictures” кино компанитай хамтран богино хэмжээний цуврал кино контентийг бүтээж байна.

Мэдээллийн ил тод, хүртээмжтэй байдлыг хангах, залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, чадавхжуулах зорилгоор “Бодлогод залуусын оролцоо” ТББ-тай хамтран Увс, Ховд, Завхан, Баян-Өлгий, Говь-Алтай аймгийн залуучуудын дунд “Орон нутгийн төсвийн ил тод байдал” хакатон /*тодорхой өгөгдсөн сэдвийн хүрээнд төрөл бүрийн мэргэжил, чадвартай хүмүүсээр үр дүнтэй багийг бүрдүүлэн, богино цаг хугацаанд шинэ санааг хөгжүүлж асуудлыг оновчтой, бүтээлчээр шийдвэрлэх нэг төрлийн уралдаант үйл ажиллагаа*/ -ыг зохион байгуулав.

Түүнчлэн шударга ёсны үзэл санааг олон нийтэд төлөвшүүлэн, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, иргэдийн идэвх санаачилгыг өрнүүлэх, идэвхжүүлэх, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор “Үнэгүй фитнес” ТББ-тай хамтран “Эрүүл бие-Эрүүл нийгэм” аяныг зарлаж, энэ хүрээнд “Амьдралын хэв маягаа өөрчилье” уриан дор 300 гаруй иргэнийг хамруулсан “Let’s change” сэдэвт өдөрлөгийг 2020 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр Үндэсний соёл, амралтын хүрээлэнд зохион байгууллаа.

Төрийн байгууллагуудаас авлигын эсрэг үйл ажиллагааг үр дүнтэй төлөвлөх, тайлагнах, арга зүйг боловсруулах, үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тодорхой болгох, сайн туршлагыг солилцох чиглэлээр “Авлигын эсрэг үйл ажиллагааны байгууллагын төлөвлөлт, үр дүнг сайжруулах-арга зүйн асуудал” сэдэвт уулзалт, хэлэлцүүлэг, хөндлөнгийн шинжээчээр гүйцэтгүүлсэн “Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ”-ний тайлангийн хэлэлцүүлэг, “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаан дахь хяналт, оролцооны талаарх хууль тогтоомжийн хэрэгжилт” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулж, мэргэжлийн судлаачид, салбарын мэргэжилтнүүд, төрийн бус байгууллагуудын төлөөллийг оролцуулан мэдээ, мэдээлэл, санал солилцооноор дээрх чиглэлээр цаашид баримтлах бодлого, чиглэлийг тодорхойлоход ач холбогдол бүхий уулзалт боллоо.

1.4 Хуулийн 18 дугаар зүйлийн 18.4.2 дахь хэсэгт заасан “авлига гарч болох нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзвэл төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, журам, дүрмийг хянаж хүчингүй болгуулах санал боловсруулж эрх бүхий байгууллагад оруулах” чиг үүргийг хангах хүрээнд нийт 18 дүрэм, журмыг хяналаа. Үүнд:

Монголбанкны ерөнхийлөгчийн 2008 оны 316 дугаар тушаалаар баталсан “Монголбанкнаас банк, банкны ажилтнуудын үйл ажиллагаатай холбогдсон эрүү, иргэний хэрэгт магадлан шинжилгээ хийх журам”-ыг хянан хүчингүй болгуулахаар саналыг хүргүүлэв.

Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжүүлэх төсөв, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”, 2019 оны 131 дүгээр тушаалаар баталсан “Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам”, 2019 оны 132 дугаар тушаалаар баталсан “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам”, 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжүүлэх төсөв, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 274 дүгээр тогтоолоор баталсан “Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрэм”, “Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журам”, 2012 оны 115 дугаар тогтоолоор баталсан “Худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих журам”-д авлига, ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй нөхцөл боломж байгаа эсэхийг хянан үзэж, шаардлагатай саналыг хүргүүлэв.

“Суралцагчийн сургалтын төлбөр, амьжиргааны зардалд зориулан олгох хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн улсын төсвийн оролцоотой эх үүсвэрийг бүрдүүлэх, эргэн төлүүлэх, сургалтын зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох журам”-ын төсөл, “Согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох журам”, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/146 дугаар тушаалаар баталсан “Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс хураагдсан баялаг, эд зүйлийг шийдвэрлэх журам”, “Гаалийн тусгай бүсийн бүрдүүлэлтийн горим хэрэгжүүлэх журам”, “Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа,

тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам”, “Чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх журам”, “Гаалийн хяналтын бүсийн журам”, “Гаалийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журам”, “Бүрдүүлэлтийн дараах шалгалт хийх заавар”, “Импортын барааны гаалийн үнийг шалгах, гаалийн үнийг тодорхойлох журам”, Зам тээврийн салбарын “Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ын төсөл зэргийг хянаж, холбогдох санал, зөвлөмжийг хүргүүлээ.

1.5 Хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5 дахь хэсэгт заасан “Авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд ухуулан сурталчлах ажлыг тасралтгүй явуулах, олон нийтийн авлигын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, түүнтэй тэмцэх арга барилд сургах ажлыг зохион байгуулах чиглэлээр сургалт, сурталчилгаа хийх” чиг үүргийн хүрээнд дараах ажил, арга хэмжээг зохион байгуулав. Үүнд:

Тайлант хугацаанд авлига, ашиг сонирхын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэдний мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх, чадавхижуулах чиглэлээр 13820 хүнийг сургалтад хамруулж, 2190 хүнд цахим сургалт хийсэн дүнтэй байна. Сургалтыг салбар, мэргэжил тус бүрээр төрөлжүүлэн зохион байгуулсан нь шинэлэг байв.

2020 оны 1 дүгээр сарын 20-24-ний өдрүүдэд Монгол Улсад суугаа АНУ-ын ЭСЯ-тай хамтран Монгол улсад ФАТФ-аас өгсөн зөвлөмжийн 7 дугаар хэсгийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу “Мөнгө угаах гэмт хэргийн арга хэлбэр, хууль бус мөнгийг илрүүлэх арга” санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны сургалтыг АТГ, ТЕГ, ЦЕГ, ХСИС, УЕПГ, Монгол банкны холбогдох алба хаагчдыг хамруулан зохион байгууллаа.

Дэлхийн банк болон НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны хамтарсан санаачилга СтАР /StAR/-аас “Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны арга зүй” сэдэвт сургалт, ахисан түвшний сургалтыг 4, 5 дугаар сард 3 удаа цахимаар зохион байгуулж албан хаагчдыг хамруулан суралцуулав.

Дэлхийн банк болон НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны хамтарсан санаачилга СтАР /StAR/-аас МШХ, ГАХ-ийн нийт мөрдөгчдөд зориулан “Гадаад улсын хөдлөх, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн системээс мэдээлэл авах нь” сэдэвт семинарыг 9 дүгээр сарын 30-ны өдөр, 10 дугаар сарын 12-22-ны өдрүүдэд Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны дунд түвшний сургалтыг тус тус зохион байгуулж АТГ, УЕПГ, ЦЕГ-ийн холбогдох албан хаагчдыг хамрууллаа.

2020 оны 9 дүгээр сард БНСУ-ын Авлигын эсрэг болон Иргэний эрхийн хорооноос санаачлан зохион байгуулсан НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн 2, 5 дугаар хэсгүүдэд чиглэгдсэн тэтгэлэгт сургалтад холбогдох хэлтсийн албан хаагчдыг суралцуулав.

БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонконгийн Авлигын эсрэг бие даасан хороотой хамтран ажиллах хүрээнд “Санхүүгийн хэмнэлттэйгээр авлигаас урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг 10 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулж, УССГХ-ийн албан хаагчдыг хамрууллаа.

Авлигын нийгмийн аюулыг ухуулан таниулах, хууль тогтоомж сурталчлах, авлигатай тэмцэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төр-иргэний хамтын ажиллагааг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, иргэдийн эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, олон нийтийн хяналтын тогтолцоог бүрдүүлэх, сайн туршлагыг дэлгэрүүлэхэд чиглэсэн олон төрлийн сургалтын хөтөлбөр, модулийг боловсруулж, үйл ажиллагаандаа нэвтрүүлээд байна. Тухайлбал, Иргэний нийгмийн байгууллагыг чадавхижуулах зорилгоор “Шударга ёс-Иргэний хяналт” сэдэвт, төрийн албаны удирдах албан тушаалтан, худалдан авах алба, хуулийн хэлтэс, санхүү, дотоод хяналт, аудитын албан тушаалтнуудад зориулсан 5 төрлийн 20 сургалтын модулийг боловсрууллаа. Мөн хувийн хэвшлийн салбар, бизнес эрхлэгчдэд зориулсан гар утас, бусад хөдөлгөөнт төхөөрөмж дээр ажиллах сургалтын интерактив модуль бүхий аппликэйшний зохиомжийн төслийг боловсруулах, ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн хичээл, сургалтын хөтөлбөрт шударга ёсны үзэл, хандлага, авлигыг үл тэвчих үзэл, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдэв хэрхэн туссан байдалд дүн шинжилгээ хийх ажлыг эхлүүлэв.

Авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд ухуулан сурталчлах ажлыг тасралтгүй явуулж байна. Тайлант хугацаанд авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигын

эсрэг хууль тогтоомжийг ухуулан сурталчлах, авлигын нийгмийн хор аюулыг тайлбарлан таниулах зорилгоор 16 төрлийн гарын авлага, эмхэтгэл, Тухайлбал, “Албан тушаалын гэмт хэргийн шүүхийн шийдвэрийн эмхэтгэл 2011, /2012/, /2014/, /2015/”, шинээр сонгогдсон УИХ-ын гишүүн, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын төлөөлөгчдөд болон шинээр эмхлэн байгуулагдсан Засгийн газрын гишүүдэд зориулсан гарын авлага, “Шударга байдал ба олон нийтийн итгэл” сэдэвт хуулийн байгууллагын нэгдсэн зөвлөлгөөнд хэлэлцүүлсэн илтгэл, “Үнэт зүйлийн боловсрол” лекцийн эмхэтгэл, “Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг буцаан авах ажиллагаа” сэдэвт, ерөнхий боловсролын сургуулийн сурагчид багш нарт зориулсан, “Бодлогын хураамж: Төрийн албаны ёс зүй, ашиг сонирхлын зөрчил” гарын авлага, хувийн хэвшлийн шударга байдлыг нэмэгдүүлэх, шударга өрсөлдөөн, хууль дээдлэх үзлийг төлөвшүүлэх, нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор судлаач П.Мөнхтогттой хамтран “Нийгмийн хариуцлагын бүрэн зураглал” гарын авлага боловсруулж хэвлүүлэн, олны хүртээл болгов.

Улсын Төв номын сан, Улаанбаатар хотын төв номын сан, МУИС-ийн номын сангуудад байрлаж байгаа номын буланд, түүнчлэн 21 аймгийн номын сан, Улаанбаатар хотын 73 байгууллагын номын санд шаардлагатай ном, гарын авлагаар баяжилтыг хийж байна.

“АТГ-Олон нийтийн төв” фэйсбүүкийг нээж, мэргэжлийн байгууллагатай хамтран идэвхижүүлэлтийн арга хэмжээг зохион байгуулсан ба 31115 дагагчтай болсон ба тус пэйжээр дамжуулан 335 зурагт хуудас болон бусад мэдээ мэдээллийг байршуулж, 486 мэдээлэл, 151 видео контентийг олон нийтэд хүргэсэн байна.

Авлигын хор хөнөөл, шударга зүйлд иргэд, олон нийт, төрийн албан хаагчдыг уриалах, авлигын эсрэг үйл ажиллагаанд тэднийг татан оролцуулах зорилгоор зорилтот бүлгүүдэд зориулсан видео контентуудыг цувралаар тогтмол бүтээж, цахим хуудас, пэйжээр, болон телевизүүдтэй хамтран түгээх ажлыг зохион байгуулж ажиллаж байна. Нийт 38 төрлийн видео контент бүтээлээ. Тухайлбал, Жүжигчин С.Ариунбямбын тоглосон 1/ “Шударга ёсны үнэ цэнэ”, СТА жүжигчин Б.Амарсайхан тоглосон 2/ “Төрийн албан хаагч танаа”, Жүжигчин Б.Мөнхбаяр тоглосон 3/ “Авлигын шилэн бөмбөг”, жүжигчин СТА Р.Адьяа, СТА Ө.Мөнх-Эрдэнэ, СТА Х.Манлайбаатар нар тоглосон 4/ “Хожихгүй нүүдэл”, СТА жүжигчин Н.Ялалтын тоглосон 5/ “Эгэл ардын зарлиг” видео контент, жүжигчин Ц.Мөнхболд, Б.Ган-Эрдэнэ, Х.Жаргал нар тоглосон 6/ “Авлигын цаана” нэртэй богино хэмжээний кино, Сагсан бөмбөгийн шигээ багийн тамирчдын тоглосон 7/ “Авлигын эсрэг олуулаа нэгдье”, “Гэрэл тусгая” цуврал: 9/ “Арын хаалга...”, 10/ “Албаны мэдээллийг аминдаа...”, 11/ “Гайтай бэлэг...”, 12/ “Танилын гуйлт...”, Залуу удирдах төрийн албан тушаалтнуудад зориулж авлига албан тушаалаа ашиглаж бусдаас хээл хахууль авснаар эцэст амьдрал яаж сүйдэж байгааг энэ нь хар дарсан зүүд мэт байсныг харуулсан дууны үг, ая, клип болон хүүхэд багачуудад зориулсан 11/ “Шударга тоглоё” хүүхдийн дуу, 12/ клип, 13/ “Шударга ёс” цувралын эхний анги, 14/ “Хичээл дээр, Зөв зөвд шударга зөв” г.м нийт 38 видео контентийг бүтээж, олон нийтэд цахимаар болон телевиз, ил харагдах дэлгэцээр түгээх ажлыг цувралаар зохион байгуулж ажиллав.

Мөн телевизийн “SBN news” мэдээллийн хөтөлбөр, баасан гараг бүрийн “Баримтын хайрцаг” баримтад тулгуурласан сурвалжилга, хүүхдийн “Нахиа” хөтөлбөр, амралтын өдрийн “Дуртай өдөр” хөтөлбөр зэрэг контентуудаараа дамжуулан олон нийтэд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх мэдээ мэдээллийг хүргэж ажиллаж байна. АТГ-аас хийсэн видео контент, шторк, дуу клип, богино хэмжээний кино зохиомжит нэвтрүүлэг зэргийг баруун 4 зам Жэм палас, 4-р хороолол “УБ палас”-ын хойно байрлах Жэм молл лед дэлгэц, R&P Entertainment TV, Оргил TV, Богц TV, Гэгээ TV, Дуу шүлэг TV, Сэдэв TV онлайн телевизээр, гэрээгээр ажилладаг арилжааны телевизүүдээр цацах гэрээ байгуулж ажиллаж байна.

Мөн тайлант хугацаанд бүтээгдсэн видео контентуудыг улсын хэмжээний 25 телевиз, кабелийн сувгаар дамжуулж олон нийтийн хүртээл болгох ажлыг зохион байгуулж, цацалтад мониторинг хийн ажиллав.

“Гэр бүлийн радио 104.5”, “Дэлхийн монголчуудын радио 88.3”, “Таны радио 103.6”, “Зохист аялгуу 89.3” радиотой хамтран ажилласнаар “Нэг дусал”, “Радио зөвлөгөө”, “Ашигтай мэдлэг”, “Уран зохиолын цаг” зэрэг олон сонсогчтой нэвтрүүлгээр дамжуулан авлигын хор аюулыг ухуулан таниулахад чиглэгдсэн мэдээ, мэдээллийг тогтмол урсгалтай болов.

Хаштаг 110 подкаст нэвтрүүлгийг цувралаар хийж, mpus.mn сайтад 51 удаагийн мэдээлэл байршуулсан байна.

Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигын талаар гомдол мэдээлэл хүлээн авах тусгай дугаарыг сурталчилсан видео контентуудыг нэр бүхий 22 телевиз, кабелийн сувгаар дамжуулан олон нийтийн хүртээл болгох ажлыг зохион байгуулж, нийт 2397 удаагийн цацалтад хийгдсэн дүнтэй байна.

Радиогийн нэвтрүүлгээр дамжуулан иргэдийн авлигын эсрэг мэдлэг, мэдээллийг дээшлүүлж, иргэдийн оролцоог хангаж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхтэй холбоотой мэдээллийг хүргэх зорилгоор Гэр бүлийн радио 104.5, MGL 88.8 радиотой хамтран ажиллаж байна. Цахим орчинд мэдээлэл түгээх хүрээнд “Хаштаг 110” подкаст /аудио хэлбэрээр мэдээлэл түгээх/ сувгийг үүсгэн, авлигын эсрэг 51 контент, SBN телевизтэй хамтран мэдээлэл, баримт, фактад тулгуурласан “Баримтын хайрцаг” 3 удаагийн цуврал нэвтрүүлгийг бэлтгэж, олон нийтэд хүргэлээ.

“Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”-ын хэрэгжилтийг хангах хүрээнд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль зөрчсөн үндэслэлээр сахилгын шийтгэл ногдуулсан 25 албан тушаалтны талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газрын цахим хуудас, “АТГ-Олон нийтийн төв” пэйж хуудсанд байршуулж, олон нийтэд мэдээлэв.

Түүнчлэн нийслэлийн Сууц өмчлөгчдийн холбоодтой хамтран Улаанбаатар хотын орон сууцны болон 15 оффисын цахилгаан шатанд байршуулсан 218 электрон дэлгэцээр авлигын эсрэг мэдээлэл, сурталчилгааг нэвтрүүлэх, зурагт хуудас, нугалбар танилцуулга (брошюр), үзүүлэн тараах материал, мэдээллийн самбарт байрлуулах мэдээллийг бэлтгэн хэвлүүлж, сурталчилгааны ажлыг тасралтгүй зохион байгууллаа.

Авлигын эсрэг олон улсын өдрийг угтан “Зөв зөвд шударга зөв” соён гэгээрүүлэх аян, арга хэмжээг зохион явуулав. Энэ аяны хүрээнд “Good Habits 20 буюу Зөв дадал 20” дижитал чуулганыг 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдөр, “Ковид ба авлига: Иргэдийн чөлөөт индэр” цахим хэлэлцүүлэг хийлээ.

Тус аянд сэтгүүлчдийг татан оролцуулж, 15 сэтгүүлч оролцсон 15 шторк, 20 постер хийж, телевизүүд болон сошиалаар олон нийтэд түгээх, аяны баннер бүхий зурагт хуудсыг олон нийтийн газарт байршуулах, 9 төрлийн видео шторкийг лед дэлгэцээр олон удаагийн давтамжтайгаар сурталчлах, хүүхэд багачуудад зориулан бэлтгэсэн “Шударга ёс: Хичээл дээр...”, “Шударга тоглоё” видео контентоор бүжгийн челленж өрнүүлэв.

НҮБ-ын “Recover with integrity” аяны санааг тусгасан монгол хувилбарт постерыг гаргаж, постерыг мэдээллийн гол www.ikon.mn, www.zaluucor.mn, www.news.mn, www.gogo.mn зэрэг сайтуудын топ байршилд байршуулж хамтран ажиллав. Монголын сайтын холбоотой хамтран #110 подкастын “110 tips” зөвлөгөө буланд 30 цуврал контент бэлтгэсэн.

Зохиолч, сэтгүүлч, нийтлэлч нартай хамтран ажилласнаар шударга ёсны сэдвээр богино хэмжээний 20 өгүүллэг, 6 нийтлэл, 4 ярилцлага, 15 тодруулга бэлтгэн, бүтээлийн фонд бүрдүүлээд байна.

“Салхитын мөнгөний орд”, “Зайсангийн хууль бус газар олголт”, “Авлигатай тэмцэхэд иргэдийн оролцоо”, “Залуу үе авлигын эсрэг” зэрэг 4 төрлийн сэдвээр “Цахим сэтгүүл зүй” ТББ-тай хамтран баримтад суурилсан “Өөр өнцөг” нэвтрүүлгийг бэлтгэв.

Арга хэмжээний талаарх мэдээллийг телевиз, радио, цахим хуудас, фэйсбүүк болон олон нийтийн мэдээллийн бүхий л сувгаар нэвтрүүлэх ажлыг зохион байгууллаа.

1.6 Хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6 дахь хэсэгт заасан “авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлын талаар зөвлөмж гаргах, байгууллага, иргэний хүсэлтээр түүний үйл ажиллагаан дахь авлигад өртөх боломжийг багасгах талаар заавар, зөвлөгөө өгөх” чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд дараах ажил, арга хэмжээг хэрэгжүүлэв. Үүнд:

Төрийн байгууллагуудад хяналт шалгалтаар ажиллах явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, дотоод хяналт, санхүүгийн сахилга батыг сайжруулах, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааг нээлттэй болгох ажлыг эрчимжүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Монгол Улсын Ерөнхий сайд болон 21 аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нар, Сонгуулийн ерөнхий хороо, улс төрийн нам, эвсэл, сонгуульд нэр дэвшигчид, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Орон сууц, нийтийн аж

ахуйн газар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам зэрэг 20 байгууллагад зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллав. Тухайлбал,

Дэлхий нийтэд тархаад байгаа шинэ төрлийн “Ковид-19” вирусийн халдвараас сэргийлэх үйл ажиллагаанд зориулж Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудаас өгч байгаа хандив, тусламжийг хүлээн авах, захиран зарцуулахдаа Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг чанд мөрдөх, тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийн тайлан гаргах, иргэд, олон нийт орлого, зарцуулалтын талаарх мэдээллийг нээлттэй авах нөхцөл боломжийг бүрдүүлэх, хууль тогтоомж зөрчигдөх, авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг Монгол Улсын Шадар сайд, Сангийн сайд, Улсын онцгой комисс, Эрүүл мэндийн яам, Онцгой байдлын ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт;

-Төрийн байгууллагуудад хийсэн хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, дотоод хяналт, санхүүгийн сахилга батыг сайжруулах, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааг нээлттэй болгох ажлыг эрчимжүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Монгол Улсын Ерөнхий сайд болон 21 аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нарт, мөн холбогдох асуудлаар Нийгмийн даатгалын ерөнхий газар, Орон сууц, нийтийн аж ахуйн газар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд;

-Монгол Улсын Их Хурлын сонгууль зохион байгуулагдахтай холбогдуулан сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигч, Сонгуулийн ерөнхий хороонд;

-Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газарт, Зам, тээврийн хөгжлийн сайдад, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сонгинохайрхан, Налайх, Чингэлтэй дүүргийн цагдаагийн хэлтэс, Төв аймгийн Эрдэнэ, Сэргэлэн сумын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт зөвлөмж хүргүүлж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүллээ.

Хоёр. Судалгаа, шинжилгээний ажлын талаар

Авлигын эсрэг хуульд заасан үндэслэл, журмын дагуу “Шударга байдлын үнэлгээ”-ний 2019 оны судалгааг гэрээний үндсэн дээр хийлгэж, судалгааны тайланг хүлээн авч, дүнг танилцуулах, мэдээлэх ажлыг зохион байгуулав. Шударга байдлын үнэлгээнд 2019 онд 62 яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрыг хамруулсан. Урьдчилсан тооцооллоор Шударга байдлын үнэлгээ 74.1 гарсан нь 2018 оныхоос 5.4 пунктээр нэмэгдсэн байна. Шударга байдлын үнэлгээний дүнг олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгууллаа.

Шударга байдлын үнэлгээний 2020 оны судалгааны ажлыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, түүний хэрэгжүүлэгч агентлаг, харьяа байгууллагын хүрээнд гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарлаж хууль тогтоомжид заасан ажиллагааг хийж байна.

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн авлигын талаарх ойлголт төсөөллийг тодруулах судалгаа”-г зохион байгуулан, үр дүнг олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулав. Түүнчлэн судалгааны үр дүнг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яам болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газарт хүргүүлснээр судалгааны үр дүнг үндэслэн уулзалт зохион байгуулсан.

“Төрийн байгууллага дахь авлигын эрсдэлийн үнэлгээ” хийх ажлыг Биеийн тамир, спортын газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрыг хамруулан зохион байгуулж, үнэлгээний үр дүнг тухайн байгууллагуудад хүлээлгэн өглөө. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяа Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны харьяа Жижиг, дунд үйлдвэрийн газар, Барилга, хот байгуулалтын яамны харьяа Барилгын хөгжлийн төв, Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын Тамгын газар, нийслэлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, Зээлийн батлан даалтын сангийн авлигын эрсдэлийн үнэлгээ хийх ажлыг гэрээгээр гүйцэтгүүлэх ажлыг эхлүүлж, эхлэлтийн болон явцын тайланг хүлээн аваад байна.

“Улс төр, шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа”-г гэрээгээр гүйцэтгүүлж байна.

“Хүүхдийн шударга байдал” 2020 оны судалгаанд 5469 сурагч, 601 эцэг, эхээс асуулга авч, тайланг боловсруулж байна. Бангладеш Улсын эцэг эхийн зөвлөлийн тэргүүн туршлагыг нэвтрүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори 12 дугаар сургуулийн сурагчид, эцэг, эхчүүдийн шударга байдлыг үнэлэх судалгааг зохион байгуулаад байна.

“Авлигын нөхцөл байдлын системийн динамик загварчлал боловсруулах” ажлыг гэрээгээр гүйцэтгүүлэхээр ажлыг эхлүүлж, загварчлал Vensim DSS программ хангамжийг хэрэглэх эрхийг худалдан авав.

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргадаг 4800 нийтийн албан тушаалтнаас хөрөнгө, орлогын мэдүүлгийн системийн үйл ажиллагаа, мэдүүлгийн маягт, авлигыг мэдээлэх асуудал, эрх бүхий албан тушаалтнуудын үйл ажиллагаа, гомдол мэдээлэл хүлээн авах, шалгахад мэдээлэгчийн нууцлалыг хангах судалгааг авч, тайланг боловсрууллаа.

2018, 2019 онд авлигын эрсдэлийн үнэлгээнд хамрагдсан төрийн 39 байгууллагатай холбогдуулан иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын тоон мэдээлэлд, улс орнуудын хөрөнгө, орлогын мэдүүлгийн системийн судалгаа, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэгжлэг хийх талаарх олон улсын эрх зүйн зохицуулалтын талаар тус тус судалгааг хийсэн ба хүн амын амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийн иргэдийн авлигын талаарх ойлголт, хандлагыг тодорхойлох, Засгийн газрын тусгай сангуудын үйл ажиллагаанд судалгаа хийхээр бэлтгэл ажлыг хангаж байна.

Нийгмийн сүлжээ ашиглан олон нийтийн сэтгэл зүйд нөлөөлж байгаа байдал, авлигатай тэмцэх нөхцөл байдалд, Монгол Улсын Их Хурлын 2020 оны сонгуульд нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөрт авлигатай тэмцэх чиглэлээр тусгагдсан зорилтуудад дүн шинжилгээ хийв.

“Шударга ёс” онол, арга зүйн цувралын 2 дахь дугаарыг хэвлэлтэд шилжүүлээд байна. Авлигын гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тогтоох аргачилсан зөвлөмж (гарын авлага)-ийг бэлтгэн үйл ажиллагаанд ашиглах нөхцөлийг бүрдүүлэв.

Гурав. Хяналт шалгалт, дүн шинжилгээний ажлын талаар:

3.1 Мэдүүлгийн бүрдүүлэлтийн талаар-Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалтнуудын 2019 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг /ХАСХОМ/-ийг шинэчлэн бүртгэх ажлыг улсын хэмжээнд удирдан зохион байгуулав. Авлигын эсрэг хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасныг үндэслэн Төрийн захиргааны болон нутгийн захиргааны нийт 110 байгууллагаас ХАСХОМ-ийн талаарх тайлан, мэдээг хүлээн авч, нэгдсэн дүн мэдээг гаргалаа.

ХАСХОМ-ийг шинэчлэн мэдүүлэх хуулийн хугацаанд буюу 2020 оны 2 дугаар сарын 15-ны дотор улсын хэмжээнд нийт 41686 албан тушаалтан /цахим хэлбэрээр-37527, хэвлэмэл байдлаар-4158/ мэдүүлгээ гаргаж бүртгүүлэхээс хуулийн хугацаанд 41685 албан тушаалтан мэдүүлж, 1 албан тушаалтан мэдүүлгээ хуулийн хугацаанд бүртгүүлээгүй.

Хүснэгт 1. ХАСХОМ гаргасан мэдүүлэг гаргагчдын тоон үзүүлэлт /сүүлийн 3 жилийн байдлаар/

Үзүүлэлт		2017	2018	2019
Бүрдүүлбэл зохих		40073	41382	41686
Бүрдүүлсэн нийт мэдүүлэг гаргагчийн тоо		40067	41381	41685
Үүнээс:	Хугацаа хожимдуулж мэдүүлсэн	4	-	-
	Мэдүүлгээ гаргаж өгөөгүй	2	1	1
Бүрдүүлэлтийн хувь		99.99	99.99	99.99


2019 оны мэдүүлэг шинэчлэн гаргасан нийт мэдүүлэг гаргагчдын тоо өмнөх оноос **304** нэгжээр нэмэгдсэн байгаа нь зарим төрийн байгууллага буюу МЭҮГ, ШШГЕГ, АТГ, ОБЕГ зэрэг байгууллагуудын бүтэц орон тоо өөрчлөгдсөн, мөн БСШУСЯ-ны харьяа Шинжлэх ухааны академийн 54 албан тушаалтан, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн удирдах 23 албан тушаалтан ХАСХОМ гаргах жагсаалтад шинээр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. 2019 онд нэмэгдсэн мэдүүлэг гаргагчийн албан тушаалын ангилал, зэрэглэл

Нэмэгдсэн мэдүүлэг гаргагчийн тоо	Албан тушаалын ангилал, зэрэглэл			
	ТЗ	ТҮ	ТТ	ТӨХХ, ОНӨААТҮГ
304	34	20	217	33


Нийт мэдүүлэг гаргагчийн 11021 буюу 26.4 хувь нь төрийн захиргааны, 13289 буюу 31.9 хувь нь төрийн тусгай, 7518 буюу 18 хувь нь улс төрийн, 4746 буюу 11.4 хувь нь төрийн үйлчилгээний удирдах, 283 буюу 0.7 хувь нь төрийн өндөр болон Авлигатай тэмцэх газарт мэдүүлгээ бүртгүүлдэг, 2538 буюу 6.1 хувь нь төрийн болон орон нутгийн өмчит компанийн удирдах, 2291 буюу 5.5 хувь нь бусад албан тушаалтнууд байна.

Хүснэгт 3. ХАСХОМ мэдүүлсэн албан тушаалтнууд /төрийн албаны ангиллаар/



Мэдүүлэг гаргагчдын 23302 буюу 55 хувь нь Улаанбаатар хотод, 18384 буюу 45 хувь нь орон нутагт 12102 буюу 29 хувийг ахлах мэргэжилтэн, түүнээс дээш ангиллын удирдах, 29583 буюу 71 хувь нь гүйцэтгэх албан тушаалтан байна. Орон нутгаас Хөвсгөл аймгаас 1186 мэдүүлэг гаргагч бүртгүүлсэн нь бусад аймгуудаас өндөр үзүүлэлт болж байна.

Хүснэгт 4. Мэдүүлэг гаргагч /аймгаар/



Төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагаас ирүүлсэн тайлан, мэдээний дүнгээс үзэхэд Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т заасан үндэслэлийн дагуу “хөрөнгө, орлогын их хэмжээний өөрчлөлт”-ийн талаар мэдүүлсэн 644, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасныг үндэслэн “тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн мэдэгдэл” гаргасан 36487, мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасан “ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдэл” гаргасан 705 мэдүүлэг гаргагч байна.

3.2 Авлигатай тэмцэх газарт мэдүүлгээ бүртгүүлдэг төрийн өндөр болон бусад албан тушаалтнуудын мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааны талаар- Авлигын эсрэг хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-т заасны дагуу Авлигатай тэмцэх газарт мэдүүлгээ бүртгүүлэх үүрэгтэй төрийн өндөр болон бусад 290 албан тушаалтнаас албан үүргээ гүйцэтгэж байгаа мэдүүлгээ шинэчлэн гаргаж бүртгүүлвэл зохих 283 тушаалтан бүртгүүлсэн болно.

Тайлант хугацаанд Авлигатай тэмцэх газарт мэдүүлгээ бүртгүүлэх үүрэгтэй төрийн өндөр болон бусад албан тушаалтнаас шинээр томилогдсон 12, их хэмжээний өөрчлөлт мэдүүлсэн 10 албан тушаалтан хуулийн хугацаанд мэдүүлгээ гаргаж бүртгүүлсэн байна.

Авлигатай тэмцэх газарт мэдүүлгээ бүртгүүлэх үүрэгтэй төрийн өндөр, түүнтэй зэрэг зиндаа адилтгах нийт 139 албан тушаалтан шинээр томилогдсон/сонгогдсон (Улсын Их Хурлын гишүүн-67, сайд-13, дэд сайд-15, Төрийн нарийн бичгийн дарга-7, элчин сайд-1, Ерөнхий консул-1, консул-1, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга-1, агентлагийн дарга-24, бусад-9) болон хөрөнгө, орлогод орсон их хэмжээний өөрчлөлтийг мэдүүлсэн 18 албан тушаалтан мэдүүлгээ мэдүүлснийг хуулийн хугацаанд хүлээн авч, хяналт тавин ажиллалаа.

Авлигын эсрэг хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2, 14.3-т заасан үндэслэл болон төрийн албаны ил тод байдал, төрийн албан хаагчийн хариуцлагатай, шударга байдлыг хангах, олон нийтийг мэдээлэл авах боломжийг олгох зорилгоор хуваарийн дагуу төрийн болон нутгийн захиргааны нийт 36832 албан тушаалтны 2019 оны ХОМ-ийн хураангуйг <http://www.xacxom.iaac.mn> цахим хуудсанд нээлттэй байршуулсан.

3.3 Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигчдийн ХОМ-ийн бүрдүүлэлтийн талаар- Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль шинэчлэгдэн батлагдаж мөрдөгдсөнтэй холбогдуулан тус хуулийн 32 дугаар зүйлийн 32.4, 32.5, 32.15 дахь хэсэгт заасныг үндэслэн Сонгуулийн ерөнхий хороотой хамтран УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, нээлттэй мэдээлэх ажлыг зохион байгууллаа. Энэ ажиллагааны хүрээнд Сонгуулийн ерөнхий хорооны дарга, Авлигатай тэмцэх газрын даргын хамтарсан 2020 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн А08/А31 дугаар захирамж, тушаалаар “Авлигатай тэмцэх газрын мэдүүлгийн бүрдүүлэлтийн систем /<https://mediuleg.iaac.mn/>-д бүртгүүлэх, Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө орлогын мэдүүлгийн бүртгэл, лавлагааны маягт”-ыг баталсныг мөрдөж ажиллав.

Авлигатай тэмцэх газрын даргын 2020 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн А/21 дүгээр тушаалаар УИХ-ын 2020 оны сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хяналт тавих, нэгтгэн, цахим сүлжээнд нээлттэй байршуулах ажлыг гүйцэтгэв. Цахим системд ХОМ гаргах эрх нь үүсгэгдсэн нийт 698 нэр дэвшигчээс 647 нэр дэвшигч буюу 92.6 хувь нь цахим системд ХОМ-ээ гаргаж баталгаажуулсан. Эдгээрээс 112 нь 2019 онд нийтийн албанд ажиллаж байхдаа хуулийн хугацаанд бүртгүүлсэн байсан бол 535 нэр дэвшигч нь ХОМ-ээ шинээр гаргаж, цахим системд баталгаажуулсан байна. Цахим систем хаагдахад ХОМ гаргах эрхийг үүсгэсэн 4 нам, 3 эвсэл, бие даагч болох нийт 51 нэр дэвшигч цахим системд баталгаажуулаагүй байна. Цахим системд үүсгэсэн мэдээллийг эцсийн байдлаар нэгтгэн боловсруулж, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.5 дахь хэсэгт заасныг үндэслэн Сонгуулийн ерөнхий хороонд нэгдсэн лавлагааг хүргүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.15 дахь хэсэгт заасныг үндэслэн Сонгуулийн ерөнхий хорооноос албажуулж ирүүлсэн, нэр дэвшигчийн үнэмлэхээ гардан авсан нийт 606 нэр дэвшигчийн ХОМ-ийн хураангуйг “<http://xacxom.iaac.mn/>” цахим системд байршуулж хуулийн хэрэгжилтийг ханган ажиллалаа.

3.4 Судалгаа, дүн шинжилгээний ажлын талаар- 2019 онд мэдүүлсэн мэдүүлгийн “Орлого” хэсгээс хамгийн өндөр орлоготой болон орлого нь өмнөх онуудаас хэт өссөн болон давтамжтайгаар өсөж байгаа албан тушаалтнуудын орлогын байдалд харьцуулалт хийж, улмаар өөрийн болон гэр бүлийн гишүүдийн үүсгэн байгуулж хувь эзэмшиж байгаа хуулийн этгээдийн үйл ажиллагааны орлого, компанийн ногдол ашиг, хөрөнгө борлуулсны орлого нь их хэмжээтэй буюу их хэмжээгээр нэмэгдсэн буюу 800.0 сая төгрөгөөс 3.0 тэрбум төгрөг хүртэлх хөрөнгө, орлоготой зарим албан тушаалтны мэдүүлгийг хянаж, үүнээс нэр бүхий 10

албан тушаалтны ХАСХОМ-д мэдүүлсэн орлого, аж ахуйн нэгж байгууллагын хувь эзэмшдэг байдал зэргийг Татварын ерөнхий газартай хамтран хянав. Энэ хүрээнд Нийслэлийн Татварын газар, Баянгол, Хан-Уул, Чингэлтэй дүүрэг, Орхон, Увс аймгийн Татварын хэлтэст мэдүүлэг гаргагч болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн үүсгэн байгуулсан хувь эзэмшиж буй нийт 17 аж ахуйн нэгж байгууллага, хуулийн этгээд, 3 иргэний санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн бөгөөд 2020 оны 6 дугаар сарын 20-ны байдлаар нийт 12 аж ахуйн нэгж байгууллага, 1 иргэний санхүүгийн үйл ажиллагаанд иж бүрэн шалгалт хийгдэж дууссан. Татварын байгууллагын шалгалтаар нийт 31.952.156.613 төгрөгийн зөрчил илэрч, 801.596.630 төгрөгийн нөхөн ногдуулалтын акт тавигдсан байна.

Төрийн өндөр албан тушаалтан болон Монгол банк, Төрийн банкны удирдах албан тушаалтнууд болох нэр бүхий 13 албан тушаалтан нь банк бус санхүүгийн байгууллага үүсгэн байгуулсан, өөрөө болон хамаарал бүхий этгээд хувь эзэмшиж байгаа нь ашиг сонирхлын зөрчил үүсгэж байгаа талаарх мэдээлэлд үндэслэн Монгол банкны нэр бүхий 5 албан тушаалтны ХАСХОМ-ийг хянасан. Хяналтаар Монгол банкны нэр бүхий албан тушаалтнууд нь ББСБ үүсгэн байгуулж, хувь эзэмшиж байгаа нөхцөл байдал, албан тушаалын давуу байдлыг ашиглахгүй байх, дотоод хяналт шалгалтыг эрчимжүүлэх, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, авсан арга хэмжээний талаар олон нийтэд ил тод мэдээлж хэвших, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар Монгол банкны ерөнхийлөгчид шаардлага хүргүүлснээр Монгол банкны ажлын байрны тодорхойлолтод “банк бус санхүүгийн байгууллага үүсгэн байгуулагч, хувь эзэмшигч биш байх” хориглолтыг тусгуулахаар болов.

Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, албан тушаалтны хариуцлага ёс зүйг дээшлүүлэх, давхар ажил эрхлэлтийн байдлыг хянах, хууль тогтоомж зөрчих асуудлыг судлан тогтоох үйл ажиллагааны хүрээнд 8 яамны 1151 албан тушаалтны нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг шалгахад зөрчилтэй байж болзошгүй 113 албан тушаалтныг нарийвчлан шалгаж, 28 албан тушаалтанд анхааруулж, Барилга, хот байгуулалтын яамны 4, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны 1 албан тушаалтанд хариуцлага тооцуулж, Батлан хамгаалах яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хуулиар зөвшөөрснөөс бусад ажил, үүрэг эрхлэхгүй байх, энэ төрлийн зөрчлийг давтан гаргахгүй байх, дотоод хяналтыг сайжруулах чиглэлээр зөвлөмжийг хүргүүлж, биелэлтэд нь хяналт тавин ажиллаж байна.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5.1-д заасныг үндэслэн нийтийн албан тушаалтны давхар ажил эрхлэлттэй холбоотой асуудлыг нэг мөр зохицуулах, Засгийн газраас баталбал зохих эрхийн актыг баталж мөрдүүлэх чиглэлээр санал хүргүүлсэн.

Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд томилогдож байгаа албан тушаалтны томилгоо, сонгон шалгаруулалтыг нээлттэй ил тод болгох, удирдах албан тушаалтны манлайлал, ёс зүйг дээшлүүлэх, төрийн албанаас халагдсан, авлигын гэмт хэрэгт ял шийтгэгдсэн этгээдийг томилохгүй байх, төсөв, санхүү худалдан авах ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Сангийн яам болон Эрчим хүчний яамны харьяа төрийн өмчит хуулийн этгээдүүд болон “Эрдэнэс Монгол” ХК-д зөвлөмж хүргүүлээ.

Зөвлөмжийн дагуу төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс тодорхой арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

“Эрдэнэт дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн удирдах болон эрх бүхий албан тушаалтны ажлын байранд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулсан, “Эрдэнэс Монгол” ХХК нь албан хаагчдын ёс зүй, мэдлэг, боловсрол, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилж, удирдах албан тушаалтны ажлын байрны тодорхойлолтыг эрхлэх асуудал, ажлын байрны чиг үүрэг, туршлага, ур чадварт нь нийцүүлэн нэгдсэн стандартын дагуу боловсруулахаар судалгааны ажлыг хэрэгжүүлсэн, “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК нь удирдах албан тушаалтны манлайлал, ёс зүйг дээшлүүлэх чиглэлээр компанийн гүйцэтгэх захирал, салбарын дарга нартай үр дүнгийн гэрээ байгуулж, сар бүр дүгнэн, ёс зүйн зөрчлөөр ажлаас халагдсан, авлига, албан тушаалын гэмт хэрэгт ял шийтгэгдсэн этгээдийг томилохгүй байх, дотоод хяналтыг сайжруулах чиглэлээр компанийн дотоод журамд тусган “Able” программд ажилтнуудын

мэдээллийн баазыг бүрдүүлэн хяналт тавин ажиллаж байгаа, “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК нь төсөв, санхүү худалдан авах үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах чиглэлээр “Увс ЦТС” ХХК, “Ховд ЦТС” ХХК, “Дөргөний УЦС” ХХК-ийн санхүүгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын бүрдүүлэлтэд хөндлөнгийн хяналт шалгалт явуулж, цаашид авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, албан тушаалтнуудын үүрэг хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 4 дэх хэсгийн 4.1.1.4-д “төрийн жинхэнэ албан хаагчийг томилох, чөлөөлөх асуудлыг төрийн өндөр албан тушаалтан болон улс төрийн намын нөлөөллөөс ангид байлгах” гэж заасныг хэрэгжүүлэх хүрээнд төрийн жинхэнэ албан тушаал эрхэлж байгаа иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид /тэргүүлэгч/-ийн судалгааг хийлээ. Судалгаанд аймаг, нийслэл, сум, дүүргийн нийт 8103 төлөөлөгчөөс 124 нь тухайн шатны сонгуульд сонгогдсоноос хойш буюу сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд төрийн жинхэнэ албан тушаалд томилогдон ажиллаж байна. Эдгээрийн 71 буюу 57.0 хувь төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд, 53 буюу 43.0 хувь нь гүйцэтгэх албан тушаалд, удирдах албан тушаалд томилогдсон 71 албан тушаалтны 48 нь аймаг, нийслэлд, 23 нь сум, дүүрэгт ажиллаж байна.

Энэ нь Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн холбогдох заалтыг зөрчиж байх тул эдгээр үйлдлийг таслан зогсоох, хууль тогтоомжид өөрчлөлт оруулах, хамтран ажиллах чиглэлээр ЗГХЭГ, Төрийн албаны зөвлөлд санал хүргүүлсэн.

Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор баталсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 4.1.1.8-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд 2017-2019 онд хууль бусаар нийтийн албанаас халагдаж, шүүхийн шийдвэрээр ажлын байранд эгүүлэн томилогдсон албан хаагчдад нөхөн олговор олголтын байдалд судалгаа хийв. Судалгаагаар нийт төрийн албанаас хууль бусаар халагдсан 2017-2019 онд 2017 онд 237 /29.8 хувь/, 2018 онд 322 /40.5 хувь/, 2019 онд 237 /29.8 хувь/, нийт 796 албан хаагчийг буцаан томилж, нийт 4094.0 сая төгрөгийн нөхөн олговор олгох шийдвэр гарсан байна. Олговол зохих нөхөн олговроос 3335.3 сая төгрөгийг олгосноос 39.8 хувийг буюу 1328.6 сая төгрөгийг улсын төсвийн олгосон байна. Иймд Захиргааны ерөнхий хууль, Иргэний хууль, Төрийн албаны тухай хуульд зааснаар төрд учирсан хохирлыг гэм буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх чиглэлээр Үндэсний аудитын газартай хамтран ажиллахаар санал хүргүүлээд байна.

3.5 Сургалт сурталчилгаа, мэдээлэл, арга зүйн ажлын чиглэлээр- Шүүхийн ерөнхий зөвлөл, Гадаадын иргэн харъяатын газар, нийслэлийн Боловсролын газар, Ашигт малтмал газрын тосны газар, Улаанбаатар хотын Гаалийн газар, Ус сувгийн удирдах газар, Тагнуулын академи, Стандартчилал хэмжил зүйн газар, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, тэдгээрийн харьяа байгууллагын болон Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 800 эрх бүхий албан тушаалтан, мэдүүлэг гаргагчдад сургалт зохион байгуулан, мэдээлэл арга зүйгээр хангаж ажиллав.

Хүснэгт 5. Сургалтад оролцогчдын тоон үзүүлэлт /3 жилээр байдлаар/



Төрийн болон нутгийн захиргааны төв болон тэдгээрийн салбар нэгж байгууллага дээр ажиллаж байгаа эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/-ын судалгааг гаргав. Одоо улсын хэмжээнд нийт 17166 мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтан ажиллаж байна. ЭБАТ-ын тоо өмнөх оны мөн үеэс 53 нэгжээр нэмэгдсэний дотор 18,1 хувь шинээр томилогдсон буюу өөрчлөгдсөн байна.

Иймд ЭБАТ-ыг мэргэшүүлэх, чадавхижуулах, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулж, мэдээлэл арга зүйгээр хангаж, “ЭБАТ-тай ярилцах хөтөлбөр”-ийг боловсруулж, 7 хоног тутмын мягмар, пүрэв гаригуудад онлайн уулзалт, ярилцлагыг хийж, фейсбүүк группээр дамжуулан харилцан мэдлэг, мэдээлэл, туршлага солилцож, мэдээлэл арга зүйгээр хангаж ажиллалаа. Шүүхийн ерөнхий зөвлөл, Гадаадын иргэн харъяатын газар, нийслэлийн Боловсролын газар, Ашигт малтмал газрын тосны газар, Улаанбаатар хотын Гаалийн газар, Ус сувгийн удирдах газар, Тагнуулын академи, Стандартчилал хэмжил зүйн газар, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, тэдгээрийн харьяа байгууллагын ЭБАТ-ууд, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар зэрэг нийт 1558 мэдүүлэг гаргагч болон удирдах албан тушаалтанд танхимын сургалт зохион байгуулж, мэдлэг, чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авлаа.

“Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтан нарт зориулсан гарын авлага” номын шинэчилсэн 7 дахь хэвлэл, загвар жишээ бүхий “Мэдүүлэг гаргагч нарт зориулсан гарын авлага”-ын шинэчилсэн 6 дахь хэвлэлтийг шинэчлэн хэвлүүлж, холбогдох байгууллага, орон нутаг, мэдүүлэг гаргагч нарт түгээсэн.


Авлигаас урьдчилан сэргийлэх, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, авлигыг үл тэвчих үзлийг иргэд, олон нийтэд төлөвшүүлэх, иргэний хяналт оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр ашиг сонирхлын зөрчил болон ХАСХОМ, ХАСУМ-ийн хяналт шалгалтаар илэрдэг нийтлэг зөрчил, анхаарах асуудлаар “Харандааны адал явдал”, анимэйшн график, видео хосолсон зохиомжит шторк, сонгуульд нэр дэвшигчээс ХОМ мэдүүлэх аргачилсан заавар бүхий видеог бэлтгэн мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулсан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны сонгуультай холбогдуулан 29 тойргийн хорооны дарга болон нарийн бичгийн дарга нийт 160 гаруй албан тушаалтныг хамруулан “Нэр дэвшигчийн ХОМ-ийг цахим системд мэдүүлэх нь” сэдвээр сургалт зохион байгуулж, нэр дэвшигчдэд зориулсан гарын авлагыг боловсруулан хэвлүүлж түгээв.

3.6 Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн хяналт, шалгалтын ажлын талаар- Тайлант хугацаанд шинээр хүлээн авсан 555, өмнөх оны үлдэгдэл 22, нийт 577 албан тушаалтны ХАСХОМ-ийг хянан шалгахаас 542-г шийдвэрлэж, 35 мэдүүлэг ажиллагаанд байна.

Шалгасан нийт мэдүүлгийн 464 буюу 85.6 хувийг төлөвлөгөөт хяналт шалгалтаар, 23 буюу 4.3 хувийг иргэний гомдол, мэдээллээр, 55 буюу 10.1 хувийг бусад хэлтэс, албадаас шилжүүлснээр хянан шалгасан байна.

*Хүснэгт 6. Мэдүүлгийн хяналт шалгалтын тоон үзүүлэлт
/өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулбал/*



Тайлант хугацаанд төлөвлөгөөт хяналт шалгалтаар шалгасан мэдүүлгийн тоо өмнөх оны мөн үеэс 128 нэгжээр, гомдол мэдээллээр шалгасан мэдүүлгийн тоо 8 нэгжээр өсч, бусад хэлтэс, албадаас шалгуулахаар шилжүүлсэн мэдүүлгийн тоо 25 нэгжээр буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 7. ХАСХОМ-ийн хяналт шалгалт

Он	ХАСХОМ					Хариуцлага тооцуулсан байдал
	Өмнөх оны үлдэгдэл	Тайлант хугацаанд хүлээж авсан	Шалгавал зохих	Шалгаж шийдвэрлэсэн	Үлдэгдэл	
2019 онд	79	324	403	381	22 /5,5/	35
2020 онд	22	555	577	542	35 /6,3/	46


Нийт шалгасан мэдүүлгийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, 161 нэгжээр буюу 42.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Хяналт шалгалтаар хөрөнгө, орлогоо үнэн зөв мэдүүлээгүй 46 албан тушаалтанд хариуцлага /сануулах-1, албан тушаалын цалин бууруулах-26, албан тушаал бууруулах-11, төрийн албанаас халах-8/ тооцуулахаар шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 11 нэгжээр өссөн байна.

Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8-д заасан “Үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн” байж болзошгүй 7 албан хаагчид холбогдох үйлдэлд мөрдөн шалгах ажиллагаа явуулахаар Мөрдөн шалгах хэлтэст шилжүүлэн шалгуулж байна.

3.7 Гомдол, мэдээллийн хяналт шалгалтын ажлын талаар- Албан тушаалтны авлига, ашиг сонирхлын зөрчлийг шалгуулахаар хандсан 656, өмнөх оны үлдэгдэл 48, нийт 704 гомдол, мэдээллийг хянаснаас тайлант хугацаанд 616-г хянан шийдвэрлэсэн бөгөөд 40 гомдол, мэдээлэл ажиллагаанд хянагдаж байна.

Хүлээн авсан гомдол, мэдээллийг өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулбал, 36 нэгжээр буюу 5.2 хувиар, хянан шийдвэрлэсэн гомдол, мэдээлэл 78 нэгжээр буюу 11.3 хувиар буурч, шийдвэрлэлт 87,5 хувьтай байна.

Хүснэгт 8. Гомдол, мэдээллийн шийдвэрлэлт



Хянан шалгасан гомдол, мэдээллээс 73 албан тушаалтанд холбогдох зөрчлийг тогтоож, үүнээс 25 албан тушаалтанд хариуцлага тооцуулж, Боловсрол, шинжлэх ухааны яам, Эрүүл мэндийн яам, Онцгой байдлын ерөнхий газар, Ашигт малтмал, газрын тосны газар, Хэнтий, Увс, Баянхонгор, Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газар зэрэг давхардсан тоогоор 64 байгууллага, албан тушаалтанд зөвлөмж, чиглэлийг хүргүүлсэн. Хуульд заасан үндэслэлээр буцаасан 31, гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй үндэслэлээр Мөрдөн шалгах хэлтэст шилжүүлсэн 116, бусад байгууллагад харьяаллын дагуу шилжүүлсэн 128, гомдлоо буцаасан 5, зөрчил илрээгүй 263 байна.

Хяналт шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдлын талаар нийт гомдол, мэдээлэл гаргагчдын 76.0 хувьд албан бичгээр, 24.0 хувьд амаар болон утсаар хариу мэдэгдсэн. Тайлант хугацаанд хүлээж авсан нийт гомдол, мэдээллийн 389 буюу 59.3 хувийг Улаанбаатар хотоос, 267 буюу 40.7 хувийг орон нутгаас ирүүлсэн байна.

Шалган шийдвэрлэсэн гомдол, мэдээллийг агуулгын хувьд авч үзвэл албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулсан, хэтрүүлсэн 18.0 хувийг, Хууль бус шийдвэр гаргаж бусдад давуу байдал олгосон 17.0 хувь, Ашиг сонирхлын зөрчил болон сонирхлын зөрчилтэй

шийдвэр гаргасан 21.0 хувь, хууль бус томилгоотой холбоотой 24.0 хувь, бусад 20.0 хувийг эзэлж байна.

3.8 Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг /ХАСУМ/-ийг хянасан талаар- 13151 этгээдийн урьдчилсан мэдүүлгийг хүлээн авснаас 13030-г хянан шийдвэрлэж холбогдох байгууллагад хариуг хүргүүлсэн, одоо 121 мэдүүлэг хянагдаж байна.

Хянасан мэдүүлгээс 2033-ыг нь цахим системээр хүлээн авсан нь нийт урьдчилсан мэдүүлгийн 35.7 хувийг эзэлж байна. 2019 онд 8 агентлаг, 5 аймгийн 40 байгууллага цахим системд бүрэн холбогдоод байсан бол 2020 онд төрийн болон нутгийн захиргааны 884 нэгжийг цахим системд холбосон нь нийт холбовол зохих нэгжийн 50.6 хувийг эзэлж байна.

Хянан шалгасан мэдүүлгээс ашиг сонирхлын зөрчил үүсэж болохуйц нөхцөл байдлыг тогтоож анхааруулсан 848, шаардлага хангаагүй үндэслэлээр 489 мэдүүлгийг буцаан хүргүүлж, 8 нэр дэвшигч тухайн албан үүргийг хэрэгжүүлэхэд илт ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдож байгааг эрх бүхий албан тушаалтанд мэдэгдсэн байна.

Хүснэгт 9. Хянан шалгасан хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг

	Хүлээн авсан	Хянасан	Үүнээс:					Үлдэгдэл
			АСЗ үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй	АСЗ үүсэх нөхцөл байдлыг анхааруулсан	Илт ашиг сонирхлын зөрчил үүсэх	Хуульд зааснаар буцаасан	Нарийвчлан шалгах	
2019 онд	8682	8627	7634	659	28	303	3	55
2020 онд	13151	13030	11684	848	8	489	1	121

2020 оны тоон үзүүлэлтийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хүлээн авсан ХАСУМ 4469 нэгжээр буюу 51.4 хувиар өссөн нь 2020 онд зохион байгуулагдсан Улсын Их Хурлын болон аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуультай холбоотойгоор төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт орсонтой холбоотой байна.

Хянан шалгасан мэдүүлгээс ашиг сонирхлын зөрчил үүсэж болохуйц нөхцөл байдлыг тогтоогдсон, Төрийн албаны тухай хуульд 23 дугаар зүйлд заасан “Төрийн албан тушаалд тавих тусгай шаардлага”-ыг хангаагүй, төрийн албаны ерөнхий шалгалт өгөөгүй, нөөцөд бүртгэгдээгүй, түүнчлэн албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг хангаагүй, сонгон шалгаруулалтад ороогүй нэр дэвшигчдийн талаарх мэдээллийг Төрийн албаны зөвлөлд хүргүүлж хамтран ажиллав.

3.9 Хяналт шалгалтаар хариуцлага тооцуулсан байдал- ХАСХОМ-ийн хяналт шалгалтаар хөрөнгө, орлогоо худал мэдүүлсэн 46, ашиг сонирхлын зөрчлийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн 25, мэдүүлгийн бүрдүүлэлтийн хяналт шалгалтаар 8, нийт 79 албан тушаалтанд Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан хариуцлага тооцуулсан байна.

Хүснэгт 10. Хариуцлага тооцуулсан байдал


№	Хариуцлагын төрөл	Шалгалтын төрлөөр			Хариуцлага тооцуулсан албан тушаалтны тоо
		Мэдүүлгийн бүрдүүлэлтийн	ХАСХОМ-ийн	Өргөдөл, гомдлын	
1.	Сануулсан	4	1	3	8
2.	Цалинг бууруулсан	4	26	20	50
3.	Албан тушаал бууруулсан	-	11	1	12
4.	Албанаас халсан	-	8	1	9
Дүн		8	46	25	79

Дөрөв. Мөрдөн шалгах ажлын талаар:

4.1 Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн талаар- 2020 онд 1020 гомдол, мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шалган шийдвэрлэж, 281 гомдол, мэдээллийг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх


тухай хуульд заасны дагуу харьяалах байгууллагад нь шилжүүлсэн. Хянан шийдвэрлэсэн гэмт хэргийн талаархи гомдол мэдээлэл өмнөх оны мөн үеэс 126 нэгжээр буюу 14.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 11. Шалгаж, шийдвэрлэсэн гэмт хэргийн талаархи гомдол, мэдээлэл




Гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг холбогдсон албан тушаалын ангиллаар нь авч үзвэл: төрийн улс төрийн 170, төрийн захиргааны 265, төрийн тусгай 364, төрийн үйлчилгээний 98, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 97, бусад буюу хувийн хэвшил, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын 38 байна.

Хүснэгт 12. Гомдол, мэдээлэлд холбогдох албан тушаалтны ангилал



Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан 1020 гомдол, мэдээллээс 462 гомдол, мэдээлэл буюу 45.3 хувьд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэг нээж, 487 гомдол, мэдээлэл буюу 47.7 хувьд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах, 27 гомдол, мэдээлэл буюу 2.6 хувийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтай тус тус прокурорт шилжүүлж, 44 гомдол, мэдээллийн үлдэгдэлтэй, шийдвэрлэлт 95.7 хувьтай байна.

Хүснэгт 13. Гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийн шийдвэрлэлт



Хүлээн авч шалгасан 1020 гомдол, мэдээллийн 662 буюу 64.9 хувийг Улаанбаатар, 358 буюу 35.1 хувийг орон нутгийн прокурорын хяналтын харьяалалтай гомдол, мэдээлэл эзэлж байна.


4.2 Мөрдөн шалгасан эрүүгийн хэргийн талаар- Тайлант хугацаанд хуульд заасан харьяаллын 1535 үйлдэлтэй, 696 холбогдогчтой, 1331 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсныг өмнөх онтой харьцуулбал 2.4 хувийн өсөлттэй байна. /2019 онд 1300 хэрэг/

Нийт шалгасан хэргийн 236 буюу 17.7 хувийг шүүхэд шилжүүлэх саналтай, 509 буюу 38.2 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хаах, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох саналтай, 48 буюу 3.6 хувийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлж, 46 хэргийг нэгтгэн шалгаж, 6 хэргийг түдгэлзүүлж, одоо 486 эрүүгийн хэргийн үлдэгдэлтэй байгаагаас хэрэг бүртгэлтийн 426 хэрэг, мөрдөн байцаалтын 60 хэрэг байна.

2019 онд мөрдөн шалгах ажиллагаа явуулсан 1300 хэргээс 156 буюу 12.0 хувийг шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлж байсан бол 2020 онд 1331 хэргээс 236 хэргийг буюу 17.7 хувийг шилжүүлсэн нь 5.7 пунктээр өссөн байна.

Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийн шийдвэрлэлт 63.5 хувьтай, шүүхээр 114 хэрэг эцэслэн шийдвэрлэгдсэн байна.

Хүснэгт 14. Хэргийн шийдвэрлэлт



Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийг Эрүүгийн хуулийн зүйл, хэсгээр ангилбал:

Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйл /Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах/- 799 буюу 52.1 хувь,

Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйл /Хахууль авах/- 207 буюу 13.5 хувь,

Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйл /Хахууль өгөх/- 108 буюу 7.0 хувь,

Эрүүгийн хуулийн 22.8 дугаар зүйл /Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/- 23 буюу 1.5 хувь,

Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйл /Үндэслэлгүйгээр хөрөнгөжих/- 41 буюу 2.7 хувь,

Эрүүгийн хуулийн 22.12 дугаар зүйл /Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах/- 21 буюу 1.4 хувь,


Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйл /Мөнгө угаах/- 30 буюу 1.9 хувь,

Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйл. /Эрүү шүүлт тулгах/- 48 буюу 3.1 хувь

Бусад хэрэг 258 буюу 16.8 хувийг тус тус эзэлж байна.

Хэрэгт холбогдон шалгагдсан этгээдийн 81 буюу 11.6 хувийг төрийн улс төрийн, 97 буюу 13.9 хувийг төрийн захиргааны, 116 буюу 16.7 хувийг төрийн тусгай, 116 буюу 16.7 хувийг төрийн үйлчилгээний, 286 буюу 41.2 хувийг төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн албан тушаалтан болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн албан тушаалтан, иргэн эзэлж байна.


Хүснэгт 15. Гэмт хэрэгт холбогдон шалгагдсан албан тушаалтан



2020 онд шалгагдсан гэмт хэргийн улмаас 12,133,529,9 сая төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад 35,640,6 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, үл хөдлөх, хөдлөх, байр, орон сууц, автомашин, тоног төхөөрөмж зэрэг 10,112,736,4 сая төгрөгөөр үнэлэгдэх эд хөрөнгө болон бэлэн мөнгийг битүүмжлэн хамгаалсан байна.

Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлүүлэлт 3.1 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 16. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлүүлэлт



4.3 Шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн хэргийн талаар- 2019 онд 68 эрүүгийн хэрэг шүүхээр шийдвэрлэгдэж байсан бол 2020 онд 114 эрүүгийн хэрэг шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 67.6 хувиар өссөн байна.

Тухайлбал: Улс төрд нөлөө бүхий этгээд болох Монгол Улсын Ерөнхий сайд асан С.Баяр, Ж.Эрдэнэбат, М.Энхсайхан, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хурлын гишүүн С.Баярцогт, Д.Эрдэнэбат, Н.Номтойбаяр, Б.Болор, Б.Батзориг, Улсын Их Хурлын гишүүн Г.Солтан, А.Ундармаа, ХХАХҮЯ-ны төрийн нарийн бичгийн дарга Д.Энхбат, “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн дарга Л.Пүрэвбаатар, Боловсролын зээлийн сангийн захирал П.Лхагвасүрэн, Автотээврийн үндэсний төвийн хэлтсийн дарга н.Батбаяр, Баянхонгор аймгийн Цэргийн штабын дарга н.Энхбаатар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга асан Ч.Алтанхуяг, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга асан Д.Мэндбаяр, Зам тээврийн хөгжлийн яамны газрын дарга Х.Оргил-Эрдэнэ, “ДЦС-2” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал С.Бямбаахүү, “Чингис хаан” банкны гүйцэтгэх захирал С.Сандагдорж, Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн захирал С.Төгсбилэг, Салхитын мөнгөний ордны хэрэг буюу шүүгч Б.Цолмонбаатар нарт холбогдох зэрэг хэргүүд анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхээр шийдвэрлэгдээд байна.

--oOo--